

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Хичээл 1



Д.МӨНХТОГОО Доктор (Ph.D),
Монголын Үндэсний музейн
Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга
Төслийн монгол талын эксперт

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Санхүүжүүлэгч: Америкийн нэгдсэн улсын элчин сайдын соёлын өвийг хамгаалах сан

Дэмжигч: Америкийн Монгол судлалын төв,
Nomad Science ТББ

Төслийн нэр: “Монголын музейн нэн ховор нэхмэл цуглуулгын хадгалалтыг сайжруулах”

Хэрэгжих үе: 2019.9 -2021.8 сар байснаа хойшилсон. 2 жил

Төслийн танилцуулга: Дэлхий даяар зарладаг төслийн уралдааны 2019 оны санхүүгийн жилд төслийн удирдагч Сандра Вандерворф, хамтрагч “Nomad Science” ТББ-ийн тэргүүн Жулиа Кларк, Монголын Үндэсний музей, Америкийн Монгол судлалын төвтэй хамтран төсөл бичин шалгарч улмаар, санхүүжилт авч энэхүү төслийг хэрэгжүүлэхээр болсон.

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



Баруун гар талаас төслийн удирдагч Сандра Вандерворф, Д.Мөнхтогоо, Жулиа Кларк

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн танилцуулга: МҮМ өмнө нь үнэт эдлэлийн сан хөмрөгийг тохижуулах, сан хөмрөгийн бүртгэлд баркодны систем нэвтрүүлэх зэрэг төсөл авч амжилттай хэрэгжүүлсэн.

Энэ удаагийн төслийн санхүүжилтийн үндсэн зорилго нь нэхмэл эдлэлийг хадгалж хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулж, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх явдал бөгөөд хоёр хэлээр гарын авлагыг (баркодын төсөл шиг) дахин гаргах болно. Төслийн хүрээнд хадгалалтын нөхцөлийг хангахдаа АНУ-ын нэхмэл цуглуулгын хадгалалтаар мэргэшсэн эксперт, мэргэжилтэн ирж үндэсний музей болон бусад байгууллагын баг хамт олонтой хамтран ажиллах юм.

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Төсөл хэрэгжүүлэх байршил:

- Байршил 1: Монгол Үндэсний музей, УБ,
- Байршил 2: Ховд аймгийн музей, Ховд,
- Байршил 3: Соёлын өвийн Үндэсний төв, УБ,
- Байршил 4: Дорнод аймгийн музей, Дорнод,
- Байршил 5: ШУА-ийн, Археологийн хүрээлэн, УБ,
- Байршил 6: Өмнөговь аймгийн музей, Өмнөговь

Төслийн эксперт, сургагч багш: Сандра.В, Д.Мөнхтоогоо

Төсөл эхэлсэн хугацаа:

2021.04.23-нд төслийн удирдагч Сандрагийн бэлтгэсэн хичээлийн материалыг оролцогч нарт илгээснээр эхэлсэн. 4 сарын 30-нд албан ёсны нээлт хийж нэгдүгээр хичээл орсон. 2 дахь удаагийн хичээл бататгах хичээл байв.

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хэрэгжүүлэх байгууллагуудын мэргэжилтнүүд:

1. МҮМ-с Д.Мөнхтогоо,
Э.Оюунтуяа, Э.Мяндасчимэг, Д.Нямсүрэн
2. СӨҮТ-с Э.Батжаргал, Г.Ууганчимэг,
3. ШУА-ийн Археологийн хүрээлэн Р.Эрдэнэцэцэг,
Н.Нандинцэцэг,
4. Ховд аймгийн музей Б.Сүхбаатар, Ч.Уранчимэг
5. Өмнөговь аймгийн музей Ц.Отгонтуяа, Б.Жаргал,
6. Дорнод аймгийн музей Б.Нарангэрэл, Б.Баярмаа

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН
ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ


Хичээл №1

Музейн нэхмэл эд өлгийн зүйл,
тэдгээрийн төрөлжилт,
хадгалалтыг хангах тухай
ерөнхий ойлголт

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

"Нэхмэл" буюу "Textile" гэдэг үг нь "нэхэх" гэсэн утгатай "texere" гэдэг үйл үг, үйлт нэрийн өнгөрсөн цагийн "нэхэгдсэн" буюу "textus", "нэхмэл" буюу "textilis" гэсэн тэмдэг нэрээс үүссэн латин гаралтай үг юм.

Суурь утас даавууны энгийн дагуу, хөндлөн утас даавууны энтэй перпендикуляр /нэг шугам дээр тэгш өнцөг үүсгэн хөндлөн огтлолцсон шугам/ байрлаж, тодорхой нэхээсний дагуу сүлжилдэн нэхэгдсэний дүнд үүссэн эдлэлийг нэхмэл эд өлгийн зүйл гэж нэрлэнэ.



МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Нэхмэл буюу текстил гэдэг үгээр анхандаа нэхмэл бөс даавууг нэрлэж байснаа сүүлдээ байгалийн болон нийлэг нарийн ширхэгтэй нэхсэн, сүлжсэн, гөрсөн, зангидсан, багцалсан утас, мөн хатгамал зэрэг механик болон химийн аргаар хийсэн даавууг ч нэрлэх болжээ. Өөрөөр хэлбэл уг ойлголтын хүрээнд нэхмэл, сүлжмэл, нэхээсгүй гэх зэрэг үйлдвэрлэсэн аргаараа нэрлэгдсэн бүх төрлийн бөс даавуу, нэхмэл, сүлжмэл материалууд багтана.

Textile-даавуу, нэхмэл эдлэл. Олон улсын нэршил нь. Textile-Англи, АНУ, Франц, Италид, Textil-Германд, Tekstil-Турк, Текстиль-Орос, Текстил/Текстир- Монгол, Солонгос, Япон, Хятадад шууд нутагшуулсан байдаг.

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Текстилийн үйлдвэрлэлийн салбар дараах төрлүүдтэй байна.

- Үүнд:
- Ноос ноолуур, ширхэгт
 - Ээрмэл
 - Нэхмэл (жинс, костюм, даавуу)
 - Сүлжмэл (сүлжмэл цамц, майк, оймс, дотуур хувцас)
 - Нэхээсгүй (эсгий, цаас, ариун цэврийн хэрэглэл, живх гэх мэт)
 - Оёмол хувцас
 - Хиймэл арьс ба үслэг
 - Техникийн текстил,
 - Анагаахын текстил,
 - Гео текстил,
 - Сансрын текстил гэх мэт.

Музейн нэхмэл эд өлгийн зүйл, тэдгээрийн төрөлжилт, хадгалалтыг хангах тухай ерөнхий ойлголт

Музейн цуглуулга, эд өлгийн зүйлсээс хамгийн эмзэг, сан хөмрөгийн орчин нөхцөлөөс хамаарч амархан гэмтэж мууддаг, урвалд оромтгой, хадгалалтын зохистой орчин шаарддаг нь нэхмэл эд өлгийн зүйл юм. Музейн эд өлгийн зүйлсийг хадгалах явдал нь тусгай горим шаарддаг, олон улсын түвшинд туршигдсан нарийн стандартыг мөрддөг мэргэжлийн үйл ажиллагаа байдаг.

Хадгалах гэдэг нь эд юмс, ачаа тээш, мөнгө төгрөг зэргийг агуулах, байлгах, элдэв эрсдэлээс хамгаалах гэсэн утгыг илэрхийлдэг тул музейн хадгалалт хамгаалалт гэдэг хоршоо үгээр биш дан хадгалалт гэдэг үгийг сонгож хэрэглэсэн болно.

Музейн нэхмэл эд өлгийн зүйл, тэдгээрийн төрөлжилт, хадгалалтыг хангах тухай ерөнхий ойлголт

“Музейн эд өлгийн зүйл” гэдэг томъёолол 1930-д онд шинжлэх ухааны эргэлтэд орж ирсэн бөгөөд ОХУ-ын музей судлаач А.М.Разгон “Музейн эд өлөг”-ийн зүйл гэдэг бол танин мэдэхүйн эх үүсвэрийн онцгой хэлбэр, музейн харилцааны системийн үндсэн элемент мөн” гэж тодорхойлжээ. Монгол Улсын музейн практикт БСШУ-ны сайдын 2005.11.08-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан “Монгол Улсын музейн сан хөмрөгийн дүрэм”-д Монгол Улсын музейн сан хөмрөгт: а) байгаль, түүх, ард түмний эдийн ба оюуны, соёлын дурсгалт зүйлс түүний дотор үнэт металл /алт, мөнгө/ үнэт чулуу/ бадмаараг, индранил, очир алмаз, ... шүр, сувд гэх мэт/-аар хэсэгчлэн буюу бүтнээр хийсэн *эд өлгийн зүйлс* харьяа байгууллага хамраахгүйгээр багтана гэж заажээ.

Музейн нэхмэл эд өлгийн зүйл, тэдгээрийн төрөлжилт, хадгалалтыг хангах тухай ерөнхий ойлголт

Музейн тухай хуульд:

4.1.4. “**үзмэр**” гэж ерөнхий бүртгэлд бүртгэгдсэн музейн өмчийн соёлын үнэт зүйлийг;

4.1.5. “**цуглуулга**” гэж нэг болон хэд хэдэн шинжээрээ харилцан холбоотой, тодорхой цаг үеийг төлөөлөх шинжлэх ухаан, урлаг, танин мэдэхүйн ач холбогдолтой үзмэрийн бүрдэл хэсгийг;

“**Олдвор**” гэж - олж авсан, учирч тохиолдсон үнэт дурсгал: **хот балгасын олдвор** (эртний хот балгасын олдсон туурь), **үнэт олдвор олох** (олсон эртний ховор зүйл)

Монгол хэлний их тайлбар толь. 2021.07.06.

<https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%BE%D0%BB%D0%B4%D0%B2%D0%BE%D1%80#>

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд: 30.1.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр, газрын хэвлий нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа **олдвор** нь төрийн өмч мөн.

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

2019 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 306 музей үйл ажиллагаа явуулж, эдгээрээс төрийн өмчийн 12, орон нутгийн өмчийн 24 музей, орон нутаг судлах танхим нийт 270 байна. Эдгээрт нийт 122781 дэсийн 258693 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл хадгалагдаж байна (Тус тоон мэдээлэлд Үндэсний номын сан, Эрдэнэсийн сан, ШУА-ын Түүх, археологийн хүрээлэн, Палентологи, геологийн хүрээлэнгийн дэргэдэх музей зэргийн тоон үзүүлэлтийг оруулаагүй болно). Улс, аймгийн музейн нийт цуглуулгын **10,4% -ийг** нэхмэл эд өлгийн зүйл, үзмэр эзэлж байна.

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Музейн нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтыг сайжруулах зорилгоор материал судлал талаас нь түүхий эд, материалаар нь музей судлал талаас нь хадгалалтыг хангах зорилгоор хэрэглээний болон хэмжээсээр нь хэрхэн төрөлжүүлж байгааг авч үзэн, Монголын үндэсний музейн нэхмэл цуглуулгыг төрөлжүүлсэн.

“Төрөл” гэдэг нь юмыг адил шинжээр нь ангилах, “ангилал хийх” гэдэг нь юмыг бүлэг хэсгээр нь төрөлжүүлэн хуваах -ыг хэлдэг. Музей судлалд үзмэр, эд өлгийн зүйлийг маш олон янзаар төрөлжүүлэн ангилдаг. Тухайлбал: шинжлэх ухааны төрлөөр нь, түүхэн цаг үеэр нь, газарзүйн байршлаар нь, гарал үүслээр нь гэх мэт.

МОНГОЛЫН НЭН ХОВОР НЭХМЭЛ ЦУГЛУУЛГЫН ХАДГАЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Сан хөмрөгийг хадгалалтын үүднээс нэхмэл эд өлгийн зүйлийг төрөлжүүлэх талаар Textile Зүүн өмнөд Азийн орнуудын музейд зориулсан гарын авлага, нэр төрөл, ангилал, үүсэл, түүхийн талаар Textiles, хадгалалтын талаар Curatorial Care зэрэг ном бүтээл гарчээ.

Материал судлал талаасаа Д.Батбаярын техникийн ухааны докторын нэг сэдэвт бүтээлд дэлхийн нэхмэлийн ширхэгтийн үйлдвэрлэл, нэр төрөл, ангилал, амьтны гаралтай ширхэгтийн физик, химийн шинж чанар, ноосны ерөнхий ангилал зэргийг авч үзсэн.

Р.Мядагмаагийн бүтээлд нэхмэлийн ширхэгт, түүний бүтэц ангилал, нэхмэл материалын анхан шатны боловсруулалт, нэхмэл материалын будаг, нэхмэл материалын эцсийн гүйцэтгэн боловсруулалт зэргийн талаар бичсэн.

Музейн нэхмэл эд өлгийн зүйл, тэдгээрийн төрөлжилт, хадгалалтыг хангах тухай ерөнхий ойлголт

Материал судлалд нэхмэл эд өлгийн зүйлийн түүхий эдийг байгалийн гаралтай, химийн гаралтай гэж 2 ангилан төрөлжүүлдэг.

Нэхмэлийн ширхэгтийн тодорхойлолт

№	Ширхэгтийн нэр	Тодорхойлолт
1	Байгалийн гаралтай ширхэгт	Хүний шууд оролцоо, боловсруулалтгүйгээр байгаль дээр өөрөө бий болдог ширхэгтүүд юм. Жишээ нь: Ноос, ноолуур, хөвөн, олс, торго
2	Дуураймал /химийн гаралтай/ ширхэгт	Химийн, физик химийн болон бусад процессыг явуулсны дүнд үйлдвэрлэлийн аргаар гарган авсан ширхэгтүүд.
3	Хиймэл ширхэгт	Байгалийн гаралтай өндөр молекулт нэгдлийн бүтцийг нь өөрчлөх замаар хиймэл ширхэгт вискоз, ацетат, целлюлоз гаргаж авна.
4	Нийлэг ширхэгт	Энгийн химийн органик нэгдлийг хооронд нь синтезлэх замаар өндөр молекулт нэгдэл болгон гарган авна. Жишээ нь: акрил, полиэстер, капрон /нейлон/
5	Амьтны гаралтай мяндсан ширхэгтэд	Бүхий л төрлийн ноос, торго багтдаг. Амьтны гаралтай ширхэгтүүд уургийн нэгдлээс тогтоно. Уураг нь амьтан ургамлын биед байгалийн нөхцөлд нийлэгжин үс, арьс, сүү, цусны бодисын үндсэн хэсгийг бүрдүүлнэ. Ноосон ширхэгтийг бүрдүүлэгч уургийн нэгдэл нь Кератин, торгог бүрдүүлэгч уураг нь Фибройн юм.

Музейн нэхмэл эд өлгийн зүйл, тэдгээрийн төрөлжилт, хадгалалтыг хангах тухай ерөнхий ойлголт

МҮМ-н нэхмэл эд өлгийн зүйлийг үүрэг зориулалт, ахуйн хэрэглээний талаас нь төрөлжүүлвэл доорх байдлаар гарсан ба бусад гэсэн төрөлд овор хэмжээ бага, хадгалалтын нөхцөлийг хангахад хүндрэлтэй биш дараах зүйлсийг оруулсан. Үүнд: дурсгалын зүйл, цээживч, нусны алчуур, дэрний уут, ханын зүүлт, чимэг, наамал, дэр, галстук /зангиа/, оймс, дурсгалын бичиг, үсний боолт, тууз, маршал погон, оройвч, хэв, зангиа, мөрдөс, чихэвч, хонх дамрын дэвсгэр, олбогны өнгө, ханцуйвч, зүүлт, үсний гэр, даавууны өөдөс гэх мэт.

1. Малгай			14. Даалин	
2. Дээл			15. Алчуур	
3. Ууж			16. Ахуйн хэрэглээний эд өлөг	
4. Хантааз			17. Туг, далбаа	
5. Хүрэм			18. Аяганы алчуур	
6. Бүс			19. Зээгт наамал	
7. Цамц			20. Бүтээлэг	
8. Өмд			21. Хатгамал	
9. Гутал			22. Хивс, ширдэг	
10. Зодог шуудаг			23. Малыг тоног, хэрэглэл	
11. Даашинз			24. Гэрийн хэрэглэл	
13. Шашны хувцас			25. Бусад	

Музейн нэхмэл эд өлгийн зүйл, тэдгээрийн төрөлжилт, хадгалалтыг хангах тухай ерөнхий ойлголт

1. Хоёр хэмжээст зүйл гэж хавтгай эсвэл урт, өргөн гэсэн хоёр хэмжээст хэлбэртэй. Жишээ нь квадрат, тэгш өнцөгт гэх мэт зүйлс орно.
2. Гурван хэмжээст зүйл гэж урт, өргөн, өндөр гэсэн 3 хэмжээстэй ертөнц дээрх ямар ч биет байж болно. Жишээ нь хүний бие, куб, конус, бөмбөрцөг, цилиндр, квадрат гэх мэт.

МҮМ-н нэхмэл эд өлгийн зүйлийн хэрэглээний болон хэмжээсийн төрөл зүйл

д/д	Хэмжээсийн төрөл	Сан хөмрөг	СХ 1		СХ 3		СХ 4		СХ 10		СХ 11		СХ 8		СХ 7		СХ 9		СХ 6		СХ 2,5		Хэлмэгдэл		танхим		Нийт		
			Буу зэвсэг, одон/ тэм	Дундад зуун	Бэлэг дурсгал	Туг дуу авиа	Тамга, тэмдэг	Археологи	Үнэт эдлэл	Партизан	Уран зураг	Угсаатны зүй	дэс	тоо,ш	дэс	тоо,ш	дэс	тоо,ш	дэс	тоо,ш	дэс	тоо,ш	дэс	тоо,ш	дэс	тоо,ш	дэс	тоо,ш	дэс
1	3 хэмжээст	Өмд														1	1			4	5	1	1			6	7		
2		Дүрэмт хувцас																							8	9	8	9	
3		Бөөгийн хувцас																			7	7			3	3	10	10	
4		Зодог шуудаг					1	1	1	1											6	6	1	2	1	1	10	11	
5		Даашинз					4	6	2	2							8	9									14	17	
6		Хангааз							3	3						4	4				10	11	1	1	3	3	21	22	
7		Хүрэм														3	3				15	15	1	1	7	7	26	26	
8		Ууж					2	2								1	1				30	34			4	4	37	41	
9		Шашны хувцас				7	9									3	3				45	69	1	1			56	82	
10		Цамц					8	22	14	19						1	1	10	16		17	26	5	5	3	4	58	93	
11		Гутал					1	1	1	1											99	111			33	38	134	151	
12		Дээл				1	1	3	3	20	21			10	10	4	4	3	5		132	137	3	3	42	49	218	233	
13		Малгай				3	3	6	7	13	15			5	5			7	7		158	183	4	4	46	50	242	274	
976																													
14	2 хэмжээст	Даалин													34	38	6	6			1	1			12	12	53	57	
15		Танка /торгон зураг/														20	21										20	21	
16		Бүс							3	3							2	7			4	4			2	8	11	22	
17		Аяганы алчуур														24	24										24	24	
18		Зээгт наамал					1	1	5	5					1	1			2	2	8	16			1	1	18	26	
19		Алчуур					1	1										13	22							4	4	18	27
20		Бүтээлэг							8	10	1	1				2	3	3	5		8	8	1	1			23	28	
21		Хатгамал					5	5	22	25	1	1				1	1	7	8	30	31	4	10			2	2	72	83
22		Хивс, ширдэг	2	2			4	4	39	39								1	1			32	40			2	2	80	88
23		Туг, далбаа				48	245	1	4	406	499								12	44					12	14	479	806	
24		Ахуйн хэрэглээний эд зүйлс					7	7	12	20						9	10									1	2	29	39
25		Гэрийн хэрэглэл												3	3	1	1					18	28			6	8	28	40
26		Мальн уналга, ачлаганы хэрэглэл																				66	83			2	2	68	85
27		Шашны эд зүйлс														44	123									3	3	47	126
28	Бусад	3	3	17	47	15	31	31	39	1	1	77	171	3	3	6	6	9	10	76	88			12	21	250	420		
1892																													
Нийт тоо ширхэг			5	5	76	305	59	95	580	702	3	3	95	189	155	241	79	137	41	43	740	882	18	19	209	247	2060	2868	

МҮМ-н нэхмэл эд
өлгийн зүйлийн
түүхий эд,
материалын
төрөлжилтийн тоо
ширхэг, хувь

Д/д	Ширхэгтийн гарал үүслийн төрөл	Материалын нэр төрөл	МҮМ-н бүртгэл дэх төрөл	тоо, ш	Хувь, %		
1	Амьтны гаралтай ширхэгт	Торго болон торгоны төрлийн материал	торго	710	24.8		
2			пүүсүү	146	5.1		
3			магнаг	86	3.0		
4			атлас	79	2.8		
5			дурдан	81	2.8		
6			торгон	33	1.2		
7			хатгамал				
8			хоргой			44	1.5
9			чисчүү			69	2.4
10			панс			38	1.3
11			сатин			36	1.3
12			үйтэн хуар			29	1.0
13			минчүү			18	0.6
14			самбай	19	0.7		
15		Ноосон материал	ноос	72	2.5		
16			цэмбэ	91	3.2		
17			одончуу	13	0.5		
18			сүлжмэл	15	0.5		
19	Ургамлын гаралтай ширхэгт	Хөвөн, ургамлын гаралтай материал	холимог	322	11.2		
20			хөвөн даавуу	498	17.4		
21			хилэн хуар	9	0.3		
22			даалимба	63	2.2		
23			ямбуу	19	0.7		
24			брезент	4	0.1		
25			жинс	9	0.3		
26			хилэн	118	4.1		
27			хамба	109	3.8		
28			тэрмэн	21	0.7		
29	Нийлэг ширхэгт	Нийлэг материал	таар	10	0.3		
30			капрон	57	2.0		
31	Арьс, үслэг материал	Арьс, үслэг материал	нейлон	16	0.6		
32			илэг	6	0.2		
33			үслэг	23	0.8		
			булга	5	0.2		

Музейн нэхмэл эд өлгийн зүйл, тэдгээрийн төрөлжилт, хадгалалтыг хангах тухай ерөнхий ойлголт

Даалгавар:

1. Үзсэн хичээлийн дагуу төсөлд оролцогч байгууллага тус бүр өөр өөрсдийн нэхмэл цуглуулга, эд өлгийн зүйлсийг хэрэглээ, хэмжээсээр нь төрөлжүүлж нийт тоог гаргана. Ингэхдээ эхлээд бүртгэлийн мэдээлэлд тулгуурлан МҮМ-н нэхмэл эд өлгийн зүйлийн хэрэглээний болон хэмжээсийн төрөл зүйл гэсэн хүснэгтийн дагуу хийнэ.
2. Дараа нь мөн өгөгдсөн хүснэгтийн дагуу бүртгэлийн мэдээлэл, өөрсдийн мэдлэгт тулгуурлан түүхий эд материалаар нь төрөлжүүлнэ.
3. Төрөлжилт хийсэн хүснэгтээ 7 сарын 26-ны дотор төслийнхний фасебоокт группт оруулна.

Музейн нэхмэл эд өлгийн зүйл, тэдгээрийн төрөлжилт,
хадгалалтыг хангах тухай ерөнхий ойлголт

**АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**